



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2021 оны ээлжит бус 01 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит бус 01 дүгээр хуралдааныг 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) хэлбэрээр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит бус хуралдаанаар “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-д өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2020 оны 89 тоот тогтоол) танилцуулга, тогтоолын төсөл, саналын товчоо, нөлөөллийн шинжилгээг хэлэлцэн шийдвэрлэсэн болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 89 тоот тогтоолын хавсралтаар “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ыг баталж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 4971 дугаарт хянуулсан бүртгүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Радио, телевизээр дамжуулах аливаа хэлбэрийн зар сурталчилгааны хязгаарлалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөрт, захиалгат, теле-худалдааны нэвтрүүлгийн талаарх зохицуулалт хийхтэй холбогдсон журмыг Зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд хяналт тавина.”, 30 дугаар зүйлийн 30.1.8-д буюу Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх үүрэг хэсэгт “радио, телевизийн хөтөлбөрт тавигдах энэ хуулийн 23, 24 дүгээр зүйлд заасан шаардлагын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх” тухай заасан болно. Телевиз нь хөтөлбөрөө бэлтгэж нэвтрүүлэхдээ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлагын 2 дугаар зүйлийн 2.1-т заасны дагуу олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн, тэнцвэртэй, бодит, мэдээ, мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх зарчмыг баримтлан олон нийтийг соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх чиглэлийг үндсэн үүрэг, зорилго болгон үзэгч, олон нийтийн эрх ашгийг дээдлэн ажиллах үүрэгтэй.

Гэвч 2021 оноос эхлэн телевизүүдийн хөтөлбөрөөр төрөл бүрийн хонжворт сугалаа худалдан борлуулах, азтан шалгаруулах зэрэг эд мөнгөний хонжворт сугалаа зохион байгуулж шууд дамжуулалт ихээр гарч, ийм төрлийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн телевизүүдийн тоо ч өдрөөс өдөрт өссөөр байна. Тус хороонд 2021 оны 11 дүгээр сараас эхлэн иргэд, телевиз үзэгчдийн зүгээс “...Телевизүүдээр эд мөнгөний хонжворт сугалаа сурталчлан борлуулах нэвтрүүлэг эрс ихэст байгаа нь телевизүүд соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх үндсэн үүргээ биелүүлэхгүй, үзэгчдийн мэдэх эрхэд халдаж, телевизийн эфирийг мөнгө олох хэрэгсэл болгож байна...” гэх агуулга бүхий гомдол удаа дараа ирсээр байна. Засгийн газрын хэрэг эрхлэх газар, ХЗДХЯ, Сангийн яам болон холбогдох бусад эрх бүхий байгууллагуудаас телевизүүдээр эд мөнгөний хонжворт сугалаа худалдан борлуулах нэвтрүүлэг гарч байгаатай холбоотой 2021 оны 4 дүгээр сараас эхлэн Харилцаа холбооны зохицуулах хороонд хандаж тодорхой арга хэмжээ авч ажиллах чиглэлээр хүсэлт, албан бичиг, шаардлага удаа дараа ирж байсан. ХХЗХ-ноос телевизүүдийн хөтөлбөрт хийгддэг хяналт, мониторингийн дүн 2022 оны 12 сарын

байдлаар Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн болон арилжааны нийт 17 телевизээр өдөрт 1-2 удаа, дунджаар 1 цагаас 1 цаг 30 минут үргэлжилсэн хугацаатай эд мөнгөний хонжворт сугалаа худалдан борлуулах нэвтрүүлэг нэвтрүүлж байна. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.4 -т заасан зохицуулалтын дагуу эд мөнгөний хонжворт сугалаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яамнаас олгодог ч телевизээр эд мөнгөний хонжворт сугалаа худалдан борлуулах нэвтрүүлэгтэй холбоотой аливаа шаардлага, зохицуулалт байхгүй байна.

Иймээс ХХЗХ-ны ажлын албанаас Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн өргөн нэвтрүүлгийн бодлого, зохицуулалт болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн баримтлах зарчмын 5.1.7-д олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн, тэнцвэртэй, бодит мэдээ, мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх гэж, 5.1.10-д үндэсний бүтээлийг дэмжин хөгжүүлэх гэж тус тус заасныг үндэслэл болгон “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын 3.18 дах заалтад эд мөнгөний хонжворт сугалаа худалдан борлуулах нэвтрүүлэгтэй холбоотой харилцааг зохицуулахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах танилцуулга, тогтоолын төслийг боловсруулж, Хорооны 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн ээлжит бус 01 дүгээр хуралдаанд хэлэлцүүлэв.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 5.1.10 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 59 тоот тогтоолыг баталсан. Тогтоолын 1 дүгээр заалтад, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-д дор дурдсан агуулгатай 3.18¹ дэх заалт нэмсүгэй. Үүнд: “3.18¹. Эд мөнгөний хонжворт сугалаа худалдан борлуулах нэвтрүүлэгт эд мөнгөний хонжворт сугалааны тохирлыг дамжуулах нь хамаарахгүй.”; 2 дугаар заалтад Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын 3.18 дах заалтад “Телевиз нь бараа бүтээгдэхүүнийг студид байрлуулж үнэ хаялцуулах, дуудлага худалдаа зохион байгуулах хэлбэрээр сурталчлан борлуулах нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй.” гэж заасныг “Телевиз нь эд мөнгөний хонжворт сугалаа болон бараа бүтээгдэхүүнийг студид байрлуулж үнэ хаялцуулах, дуудлага худалдаа зохион байгуулах хэлбэрээр худалдан борлуулах нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй.” гэж өөрчилсүгэй гэжээ. Уг тогтоолыг ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2022 оны 01/1683 албан тоотоор хүргүүлсэн. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4971 бүртгэлтэй 2020 оны 89 тоот тогтоолд оруулсан 2022 оны 59 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлтийг 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2022-12-14